



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,178,963,589.50 (нэг тэрбум нэг зуун далан найман сая есөн зуун жаран гурван мянга таван зуун наян есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад дурьдсан байгууллагуудын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 1 дугаар сарын 26-ны өдрийн А/81 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Майхан зөөврийн	2025	сайн	ш	1	801,398,479.70	801,398,479.70	Улаанбаатар хотын
2	Зөөврийн сандал	2025	сайн	ш	1	377,565,109.80	377,565,109.80	Захирагчийн ажлын алба
Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн							1,178,963,589.50	